

# БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баян-Өлгий аймгийн Онцгой байдлын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БӨА-2025/095/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="#">www.audit.mn</a>	Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ж.Айгүл
Өлгий хот	Утас: 70422954 Цахим хаяг: J_aigul@yahoo.com
2025 он	Аудитын менежер: Х.Женисбек
	Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn
	Ахлах аудитор: Д.Назгүл
	Утас: 99427301 Цахим хаяг: nazgul_1972@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	10
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	14
4.1 Ерөнхий зүйл .....	14
4.2 Материаллаг байдал.....	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
4.5.1 Завсрын аудитын талаар.....	15
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн .....	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	15
5.1 Төлбөрийн акт.....	15
5.2 Албан шаардлага.....	15
5.3 Зөвлөмж .....	16
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	17

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



## БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,  
Утас/Факс: (976) 7042-2954  
E-mail: bayanulgii@audit.gov.mn

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ОНЦГОЙ  
БАЙДЛЫН ГАЗРЫН ДАРГА  
З.АЗАТ ТАНАА

2025.01.30 № 13  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баян-Өлгий аймгийн Онцгой байдлын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баян-Өлгий аймгийн Онцгой байдлын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Баян-Өлгий аймгийн Онцгой байдлын газрын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлантай холбоотой онцлох асуудал гараагүй.

### Аудитын гол асуудал

Баян-Өлгий аймгийн Онцгой байдлын газрын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд анхаарал татах асуудал байхгүй байна.

### Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

D:\2025 он\Албан бичиг-A4.docx

00400113

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ж.АЙГҮЛ



## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эцсийн үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>1,316,588,804.69</u></b>	<b><u>1,675,304,474.36</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	-	
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	-	-
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	54,000,000.00	-
34600	Урьдчилж гарсан зардал	54,000,000.00	
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	1,262,588,804.69	1,675,304,474.36
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	913,182,728.44	1,187,131,184.36
35110	Тусгай зориулалттай материал	852,242,059.04	1,114,124,514.96
35130	Эм боох материал	60,940,669.40	73,006,669.40
35300	Бэлэн бүтээгдэхүүн	182,306,230.25	164,153,146.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	166,249,846.00	323,170,144.00
35410	Бичиг хэргийн материал	4,161,395.00	7,227,940.00
35420	Аж ахуйн материал	62,979,984.00	68,327,918.00
35430	Сэлбэг хэрэгсэл	21,641,713.00	62,726,632.00
35440	Түлш, шатах тослох материал	23,988,700.00	84,142,800.00
35450	Барилгын засварын материал	6,446,750.00	38,204,750.00
35460	Хүнсний материал	728,480.00	13,665,280.00
35470	Бусад хангамжийн материал	46,302,824.00	48,874,824.00
35600	Мал амьтад	850,000.00	850,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>5,719,440,067.25</u></b>	<b><u>6,256,217,546.60</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	5,719,440,067.25	6,256,217,546.60
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	4,932,411,067.25	5,468,537,713.26
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,893,538,201.03	4,952,938,201.03
39202	Хуримтлагдсан элэгдэл	(2,126,042,847.52)	(2,308,587,843.52)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	4,100,832,882.00	5,132,652,882.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(1,958,912,779.02)	(2,414,303,582.01)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	984,237,014.80	1,052,780,885.80
39206	Хуримтлагдсан элэгдэл	(979,229,918.26)	(987,108,163.73)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	28,575,100.73	51,391,354.73
39208	Хуримтлагдсан элэгдэл	(22,186,586.51)	(24,610,159.58)
39214	Бусад үндсэн хөрөнгө	90,769,130.20	95,212,463.20
39215	Хуримтлагдсан элэгдэл	(79,169,130.20)	(81,828,324.66)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	787,029,000.00	787,679,833.34
39301	Програм хангамж	250,000.00	960,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(250,000.00)	(309,166.66)
39303	Бусад биет бус хөрөнгө	787,029,000.00	787,029,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>7,036,028,871.94</u></b>	<b><u>7,931,522,020.96</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	-	-
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	-	-
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>7,036,028,871.94</u></b>	<b><u>7,931,522,020.96</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	7,036,028,871.94	7,931,522,020.96
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	794,950,269.92	794,950,269.92
51101	Өмч: - төрийн	794,950,269.92	794,950,269.92

<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	2,379,391,552.85	3,274,884,701.87
51210	Өмнөх үеийн үр дүн	2,808,946,878.81	2,379,391,552.85
51220	Тайлант үеийн үр дүн	(429,555,325.96)	895,493,149.02
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,861,687,049.17	3,861,687,049.17
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>7,036,028,871.94</u></b>	<b><u>7,931,522,020.96</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Тайлант оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,996,352,389.80</b>	<b>5,659,595,655.26</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>459,154,649.80</b>	<b>1,792,847,715.26</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	459,154,649.80	1,792,847,715.26
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	54,350,000.00	1,792,847,715.26
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	54,350,000.00	
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	90,317,500.00	1,124,216,683.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	314,487,149.80	668,631,032.26
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,537,197,740.00</b>	<b>3,866,747,940.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	2,411,988,500.00	3,731,741,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,411,988,500.00	3,731,741,500.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	125,209,240.00	135,006,440.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	38,233,000.00	77,348,440.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	42,042,400.00	45,218,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	44,933,840.00	12,440,000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>3,425,907,715.76</b>	<b>4,764,102,506.24</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,425,907,715.76</b>	<b>4,764,102,506.24</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	3,420,922,924.76	4,674,110,414.24
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	2,113,261,766.00	3,150,385,508.00
210101	Үндсэн цалин	899,092,392.00	1,819,115,695.00
210102	Нэмэгдэл	1,156,660,374.00	1,198,670,913.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	38,115,000.00	51,661,500.00
210104	Урамшуулал	19,394,000.00	80,937,400.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	60,361,800.00	90,809,200.00
210201	Тэтгэврийн даатгал	17,583,800.00	3,094,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,068,500.00	364,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,655,100.00	182,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	413,700.00	9,486,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	38,640,700.00	77,681,700.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	107,844,398.00	129,111,303.00
210301	Гэрэл, цахилгаан	13,085,362.00	11,684,721.00
210302	Түлш, халаалт	91,176,100.00	114,860,392.00
210303	Цэвэр, бохир ус	3,582,936.00	2,566,190.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	126,914,022.00	202,366,842.34
210401	Бичиг хэрэг	3,728,160.00	9,676,780.00
210402	Тээвэр, шатахуун	120,511,500.00	153,836,900.00

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,941,762.00	2,220,024.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	732,600.00	1,916,100.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	34,717,038.34
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>226,136,591.00</b>	<b>233,787,259.25</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	58,080,600.00	1,142,200.00
210502	Хоол, хүнс	60,509,860.00	74,259,200.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	107,546,131.00	158,385,859.25
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>37,996,000.00</b>	<b>147,678,721.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,056,000.00	
210604	Урсгал засвар	31,940,000.00	147,678,721.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>31,574,600.00</b>	<b>31,478,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	31,574,600.00	31,478,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>30,836,783.00</b>	<b>17,675,373.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	19,200,400.00	10,010,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,130,239.00	1,063,039.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	1,009,500.00	1,137,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,437,600.00	1,481,565.00
210807	Газрын төлбөр	6,059,044.00	3,982,969.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>685,996,964.76</b>	<b>670,818,207.65</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	16,948,800.00	8,755,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	2,938,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	669,048,164.76	659,125,207.65
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>4,984,791.00</b>	<b>89,992,092.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>4,414,200.00</b>	<b>9,299,200.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,414,200.00	9,299,200.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>570,591.00</b>	<b>80,692,892.00</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	570,591.00	80,692,892.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(429,555,325.96)</b>	<b>895,493,149.02</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(429,555,325.96)</b>	<b>895,493,149.02</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Тайлант оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>2,537,197,740.00</b>	<b>3,866,747,940.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,537,197,740.00</b>	<b>3,866,747,940.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	2,411,988,500.00	3,731,741,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,411,988,500.00	3,731,741,500.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	125,209,240.00	135,006,440.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	38,233,000.00	77,348,440.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	42,042,400.00	45,218,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	44,933,840.00	12,440,000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>2,536,298,740.00</b>	<b>3,849,061,936.00</b>

<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,536,298,740.00</b>	<b>3,849,061,936.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,531,313,949.00</b>	<b>3,759,069,844.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>2,113,261,766.00</b>	<b>3,150,385,508.00</b>
210101	Үндсэн цалин	892,246,866.00	1,819,115,695.00
210102	Нэмэгдэл	1,163,505,900.00	1,198,670,913.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	38,115,000.00	51,661,500.00
210104	Урамшуулал	19,394,000.00	80,937,400.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>60,361,800.00</b>	<b>90,809,200.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	17,583,800.00	3,094,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,068,500.00	364,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,655,100.00	182,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	413,700.00	182,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	38,640,700.00	86,986,200.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>107,784,898.00</b>	<b>134,083,303.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	13,157,362.00	11,684,721.00
210302	Түлш, халаалт	91,044,600.00	119,832,392.00
210303	Цэвэр, бохир ус	3,582,936.00	2,566,190.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>43,015,562.00</b>	<b>49,742,924.00</b>
210401	Бичиг хэрэг	1,949,000.00	5,631,100.00
210402	Тээвэр, шатахуун	38,391,000.00	39,191,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,974,762.00	2,220,024.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	700,800.00	2,700,800.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>54,765,400.00</b>	<b>82,746,700.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,880,400.00	1,194,200.00
210502	Хоол, хүнс	52,885,000.00	81,552,500.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>25,000,000.00</b>	<b>132,848,996.00</b>
210604	Урсгал засвар	25,000,000.00	132,848,996.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>31,574,600.00</b>	<b>31,478,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	31,574,600.00	31,478,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>45,130,883.00</b>	<b>19,706,873.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	33,494,500.00	11,995,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,130,239.00	1,063,039.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	1,009,500.00	1,137,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,437,600.00	1,527,565.00
210807	Газрын төлбөр	6,059,044.00	3,982,969.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>50,419,040.00</b>	<b>67,268,340.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	50,419,040.00	63,268,340.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		4,000,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>4,984,791.00</b>	<b>89,992,092.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>4,414,200.00</b>	<b>9,299,200.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,414,200.00	9,299,200.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>570,591.00</b>	<b>80,692,892.00</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	570,591.00	80,692,892.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>899,000.00</u></b>	<b><u>17,686,004.00</u></b>
	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>4</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)</b>	<b>-</b>	<b>-</b>

5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	899,000.00	17,686,004.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	899,000.00	17,686,004.00
2200	Дотоод эх үүсвэрээр	899,000.00	17,686,004.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	899,000.00	17,686,004.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(899,000.00)</u>	<u>(17,686,004.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	794,950,269.92	3,861,687,049.17	2,808,946,878.81	7,465,584,197.90
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	794,950,269.92	3,861,687,049.17	2,808,946,878.81	7,465,584,197.90
Тайлант үеийн үр дүн			-429,555,325.96	-429,555,325.96
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	794,950,269.92	3,861,687,049.17	2,379,391,552.85	7,036,028,871.94
2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	794,950,269.92	3,861,928,249.17	2,379,391,552.85	7,036,270,071.94
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	794,950,269.92	3,861,687,049.17	2,379,391,552.85	7,036,028,871.94
Тайлант үеийн үр дүн			895,493,149.02	895,493,149.02
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	794,950,269.92	3,861,687,049.17	3,274,884,701.87	7,931,522,020.96

#### 2.6 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Үзүүлэлт	Тайлант оны	
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,731,741,500.00	3,651,048,608.00
УРСГАЛ ЗАРДАЛ	3,731,741,500.00	3,651,048,608.00
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,722,442,300.00	3,641,749,408.00
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,228,092,600.00	3,150,385,508.00
Үндсэн цалин	1,824,677,100.00	1,819,115,695.00
Нэмэгдэл	1,270,816,600.00	1,198,670,913.00
Унаа хоолны хөнгөлөлт	51,661,500.00	51,661,500.00
Урамшуулал	80,937,400.00	80,937,400.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	90,809,200.00	90,809,200.00
Тэтгэврийн даатгал	3,094,800.00	3,094,800.00
Тэтгэмжийн даатгал	364,200.00	364,200.00
ҮОМШӨ-ний даатгал	182,000.00	182,000.00
Ажилгүйдлийн даатгал	182,000.00	182,000.00

Эрүүл мэндийн даатгал	86,986,200.00	86,986,200.00
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	134,882,600.00	134,083,303.00
Гэрэл, цахилгаан	11,695,000.00	11,684,721.00
Түлш, халаалт	119,835,400.00	119,832,392.00
Цэвэр, бохир ус	3,352,200.00	2,566,190.00
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	10,565,100.00	10,551,924.00
Бичиг хэрэг	5,631,100.00	5,631,100.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,233,200.00	2,220,024.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,700,800.00	2,700,800.00
<b>Нормативт зардал</b>	81,680,800.00	81,677,600.00
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,197,400.00	1,194,200.00
Хоол, хүнс	80,483,400.00	80,483,400.00
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	149,825,000.00	149,825,000.00
Урсгал засвар	149,825,000.00	149,825,000.00
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	22,587,000.00	20,416,873.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,995,500.00	11,995,500.00
Тээврийн хэрэгслийн татвар	1,152,200.00	1,063,039.00
Тээврийн хэрэгслийн оношлогоо	1,142,100.00	1,137,800.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,237,600.00	2,237,565.00
Газрын төлбөр	6,059,600.00	3,982,969.00
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	4,000,000.00	4,000,000.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,000,000.00	4,000,000.00
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	9,299,200.00	9,299,200.00
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	9,299,200.00	9,299,200.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,299,200.00	9,299,200.00
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	3,731,741,500.00	3,651,048,608.00
<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	3,731,741,500.00	3,651,048,608.00
Улсын төсвөөс санхүүжих	3,731,741,500.00	3,651,048,608.00
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		-
<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>		
<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	1	1
Төсвийн байгууллага	1	1
<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	112	112
Удирдах ажилтан	1	1
Гүйцэтгэх ажилтан	106	106
Үйлчлэх ажилтан	5	5
<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>112</b>	<b>112</b>
Төрийн тусгай албан хаагч (ТТ)	107	107
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	5	5

## 2.7 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

## Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>125,209,240.00</b>	<b>135,006,440.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>125,209,240.00</b>	<b>135,006,440.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	125,209,240.00	135,006,440.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	38,760,000.00	39,191,000.00
210401	Бичиг хэрэг	369,000.00	-

210402	Тээвэр, шатахуун	38,391,000.00	39,191,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>3,556,600.00</b>	<b>1,069,100.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,602,000.00	
210502	Хоол, хүнс	1,954,600.00	1,069,100.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>31,574,600.00</b>	<b>31,478,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	31,574,600.00	31,478,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>51,318,040.00</b>	<b>63,268,340.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	51,318,040.00	63,268,340.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>125,209,240.00</b>	<b>135,006,440.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>125,209,240.00</b>	<b>135,006,440.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	38,233,000.00	77,348,440.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	42,042,400.00	45,218,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	44,933,840.00	12,440,000.00
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баян-Өлгий аймгийн Онцгой байдлын газар нь харьяалах нутаг дэвсгэрийн хүн ам, мал амьтан, эд хөрөнгө, хүрээлэн буй орчин, түүх соёлын үнэт зүйлсийг гамшгаас хамгаалах, болзошгүй гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, гамшгийн эрсдэлийг бууруулах, гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог хангах, хүч хэрэгслийн чадавхыг нэмэгдүүлэх замаар иргэдийг аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

Байгууллагын зорилт нь: “Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцогч талуудын харилцан ажиллагаа, уялдаа холбоог сайжруулах, техник, тоног төхөөрөмж, хувцас хэрэгслийн хадгалалт, ашиглалтыг сайжруулж бэлэн байдлыг дээшлүүлэх, Онцгой байдлын байгууллагын ахлагч бүрэлдэхүүний нөхөн хангалт, ур чадварыг нэмэгдүүлэх” ба гамшгаас урьдчилан сэргийлэх, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хүмүүнлэгийн тусламж үзүүлэх, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллага юм.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Аймгийн Онцгой байдлын газар нь Гамшгаас хамгаалах тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хууль, Цэргийн албаны тухай хууль, Цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль, Төрийн болон албаны нууцын тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль бусад холбогдох хууль, тогтоомжуудын хүрээнд үйл ажиллагаагаа явуулдаг.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна.

Засгийн газрын 2024 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 128, 238 дугаар тогтоолоор цалингийн шатлалд өөрчлөлт орсон байна.

Сангийн сайдын 2023 оны 65 дугаар “Хөтөлбөр батлах тухай” тушаалаар аккруэл суурьт УСНББОУС-ыг нэвтрүүлэх дунд хугацааны хөтөлбөрийг батлагдсан.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2024 оны А/111 дүгээр тушаалын хэрэгжилтийг хангах зорилгоор аймгийн Онцгой байдлын газрын 2024 оны А/56 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг тус газрын санхүүгийн үйл ажиллагаа, Өлгий, Цэнгэл сум дахь Гал түймэр унтраах, аврах 31 дүгээр ангийн үйл ажиллагаанд дотоод хяналт хийсэн байна. Санхүүгийн үйл ажиллагаанаас цалин, бараа материалын бүртгэлд хяналт шалгалт хийсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баян-Өлгий аймгийн Онцгой байдлын газар нь 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэль сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2016 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн А/293 тоот тушаалаар шинэчлэн баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг мөрдөж ажилласан байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баян-Өлгий аймгийн Онцгой байдлын газрын 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2023 оны 229 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна. Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 895.5 сая төгрөгөөр буюу 12.7 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	-	-
Урьдчилгаа	54,000.00	-	(54,000.00)
Бараа материал	1,262,588.80	1,675,304.47	412,715.67
Үндсэн хөрөнгө	5,719,440.07	6,256,217.55	536,777.48
<b>Нийт хөрөнгө</b>	<b>7,036,028.87</b>	<b>7,931,522.02</b>	<b>895,493.15</b>
Өр төлбөр	-	-	-

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	7,036,028.87	7,931,522.02	895,493.15
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b><u>7,036,028.87</u></b>	<b><u>7,931,522.02</u></b>	<b><u>895,493.15</u></b>

Мөнгөн хөрөнгө авлагын данс оны эхэн ба эцэст үлдэгдэлгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 1,675.3 сая төгрөг болж оны эхнээс 412.7 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Бараа материалын нийт үлдэгдлийн 66 хувийг тусгай зориулалтын бараа материал эзэлж байна. Төсвийн хөрөнгөөр 234.8 сая төгрөгийн материал худалдан авч, үйл ажиллагаандаа 550.1 сая төгрөгийн бараа материал зарцуулсан байна. ОБЕГ болон түүний харьяа байгууллагуудаас үнэ төлбөргүй 668.6 сая төгрөгийн бараа материал хүлээн авсан байна. Он удаан жил болсон, ашиглалтын шаардлага хангахгүй бараа материалын үлдэгдэл байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 536.8 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Төсвийн хөрөнгөөр 17.8 сая төгрөгийн, ОБЕГ болон түүний харьяа байгууллагуудаас үнэ төлбөргүй 1,124.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авсан байна.

Өр төлбөрийн данс оны эхэн ба эцэст үлдэгдэлгүй байна.

Засгийн газрын оролцоо данс тайлант үеийн үр дүн 895.5 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 3,029.9 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 1,157.6 сая төгрөгөөр нэмэгдүүлж, бусад зардлуудыг бууруулж 3,398.9 сая төгрөгөөр баталсан байна.

Тус байгууллагын 2024 оны анх батлагдсан төсөв 3,398.9 сая төгрөг ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 3,398.9 сая төгрөгөөр баталсан байна.

Тайлант онд тус байгууллагын батлагдсан төсвийг 332.8 сая төгрөгөөр нэмэгдүүлж 3,731.7 сая төгрөгөөр тодотгож баталсан байна.

Анх батлагдсан төсвөөс цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 78.1 сая төгрөгөөр, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 2.0 сая төгрөгөөр, байр ашиглахтай холбоотой тогтмол зардлыг 21.8 сая төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 7.6 сая төгрөгөөр, нормативт зардлыг 58.1 сая төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 140.3 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж зардлыг 15.8 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 4.0 сая төгрөгөөр, нэг удаагийн тэтгэмж, урамшууллын зардлыг 7.9 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, тодотгосон байна.

Төрийн албан хаагчдын цалингийн шатлалд 2024 онд өөрчлөлт орсонтой холбоотой цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлуудыг нэмэгдүүлж тодотгосон байна.

#### **3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэх эх үүсвэрийн хувьд 3,741.7 сая төгрөгийг улсын төсвөөс бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 3,651.0 сая төгрөгийн санхүүжилт авч, 80.7 сая төгрөгийг хэмнэж төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,651.0 сая төгрөг буюу 98 хувьтай байна. Энэ нь үндсэн үйл ажиллагааны зардлаас хэмнэсэн 80.7 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

**Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл**

					/мянган төгрөгөөр/	
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт	
	Гамшгаас урьдчилан сэргийлэх					
1	Үндсэн үйл ажиллагааны зардал	3,722,442.30	3,641,749.40	80,692.90	98%	
2	Туслах үйл ажиллагааны зардал	0.00	0.00	0.00		
3	Ажил олгогчоос олгох тэтгэмж,	9,299.20	9,299.20	0.00	100%	
4	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх			0.00		
	<b>Дүн</b>	<b>3,731,741.50</b>	<b>3,651,048.60</b>	<b>80,692.90</b>	<b>98%</b>	

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Байгууллагуудын 2025 оны санхүү-нийцлийн аудитаар баримтлах ерөнхий чиглэлийн судалгаануудын дүн дараах байдалтай байна. Үүнд:

Аймгийн Онцгой байдлын газар нь ахмадын сангийн харилцах данс нээлгээгүй байна. ОБЕГ-ын 2024 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 9/1378 тоот албан бичгээр Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн дагуу хуваарилан олгодог төсвийг 2024 онд анги, байгууллагуудын батлагдсан төсөв дээр хуваарилан шийдвэрлэх чиглэл өгсний дагуу 2024 оны 06 дугаар сарын батлагдсан төсвийн "Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал" зардлын ангилал дээр 3.5 сая төгрөг хуваарилж зарцуулсан байна.

Тайлант онд аймгийн Онцгой байдлын газар 23.3 сая төгрөгийн хоол хүнс худалдан авах тендерийн захиалга өгч, тендерт шалгарсан компаниас худалдан авсан.

Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж, бараа үйлчилгээний бусад зардал дансаар зардлын эдийн засгийн ангилал зөрчиж зарцуулсан 10.9 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах зөвлөмж өгсөн.

Байгууллагын 2024 оны орон тооны судалгааг гаргуулж авч, хянаж үзэхэд батлагдсан орон тооны хязгаарыг баримталж ажилласан байна.

**3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

ЗГНХ, ЗДНХ түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгөөс 77.3 сая төгрөгийн, Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгөөс 45.2 сая төгрөгийн, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 12.4 сая төгрөгийн орлогыг нэмэлт санхүүжилтийн дансаар хүлээн авсан байна. Үүнээс 39.2 сая төгрөгийг тээвэр шатахууны зардалд, 1.1 сая төгрөгийг хоол хүнсний зардалд, эд хогшил урсгал засварын зардалд 31.5 сая төгрөгийг, 63.3 сая төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардалд зарцуулсан байна.

**3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**

Аймгийн Онцгой байдлын газар нь 2024 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

**3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл**

Аймгийн Онцгой байдлын газар нь 2024 онд анх батлагдсан төсвийн хүрээнд 23.3 сая төгрөгийн хоол хүнс худалдан авах тендерийн захиалга өгч, тендерт шалгарсан компаниас худалдан авсан байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баян-Өлгий аймгийн Онцгой байдлын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Назгүл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар хэрэгжүүлсэн.

Баян-Өлгий аймгийн Онцгой байдлын газар нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 23-ний өдрийн 19/25 дугаар албан бичгээр 01 дүгээр сарын 24-ний өдөр ирүүлсэн.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Баян-Өлгий аймгийн Онцгой байдлын газрын 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 3,425.9 сая төгрөгөөс 1 хувиар буюу 34.2 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгах асуудлын хүрээнд тус байгууллагын үйл ажиллагаатай холбоотой шалгахад төлөвлөсөн 33 шалгуур үзүүлэлтээр горим сорил хэрэгжүүлж, хэрэгжилтийг шалгахад алдаа, зөрчил илрээгүй.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд шилэн дансанд байршуулах төсөв, өмч, хөрөнгө зарцуулах 35.5 сая төгрөгийн 4 шийдвэрийг байршуулаагүй, шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилт 75 хувьтай ба өмнөх оны аудитаар шилэн данстай холбоотой алдаа, зөрчил илрээгүй байгаа тул зөвлөмж өгөхөөр шийдвэрлэсэн.

**4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд** Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Баян-Өлгий аймгийн Онцгой байдлын газрын 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийсэн 18.0 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгөгдсөн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага					
Зөвлөмж	1	18,010.1	1	18,010.1	100%
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>18,010.1</b>	<b>1</b>	<b>18,010.1</b>	<b>100%</b>

Тайлант оны аудитаар өмнөх оны шийдвэрийн хэрэгжилтийг давтан шалгахад хэрэгжилт 100 хувийн гүйцэтгэлтэй байна.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 80.7 сая төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрч аудитын явцад залрууллаа. Үүнд: Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг буруу тайлагнасан 80.7 сая төгрөгийн алдааг залруулав.

Энэ нь Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам, УСНББОУС 1 стандарт, толилуулга гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийтдээ 48.3 сая төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс, 1.9 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 46.4 сая төгрөгийн зөрчилд 2 заалт бүхий зөвлөмж өгсөн.

##### 5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогдоогүй.

##### 5.2 Албан шаардлага

Аудитаар 1.9 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага өгөв.Үүнд:

1. Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн “Урамшуулал олгох тухай” Б/451 дүгээр тушаалыг үндэслэн, Онцгой байдлын газрын даргын 2024 оны 05 дугаар

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

сарын 21-ний өдрийн “Урамшуулал олгох тухай” Б/38 дугаар тушаалаар нягтлан бодогч, нярав нарт газрын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар зөрчилгүй дүгнэлт авсан гэж 1,850,400 төгрөгийн урамшуулал олгож, төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын хэмжээг хэтрүүлсэн байна..

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсгийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалт, Засгийн газрын 2019 оны “Журам батлах тухай” 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2-т “Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна” гэсэн заалтыг хэтрүүлэн урамшуулал олгосон байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хууль, Засгийн газраас тогтоосон журмыг баримталж мөнгөн урамшууллыг тогтоосон хэмжээнээс хэтрүүлэн олгохгүй байх талаар албан шаардлага өгөв.

### **5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

##### 1.1.Илрүүлэлт:

Вирусийн программ худалдан авах, хамт олны зураг, өргөмжлөл, медалийн үнэ, торгууль шийтгэлийн төлбөр төлөхөд 210801 дансаар 2.1 сая төгрөгийг, төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын дунд зохион байгуулсан спортын олон төрөлт тэмцээний зардалд 210901 дансаар 8.9 сая төгрөгийг зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.8-д “байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах”-ыг хориглосон заалтууд болон Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-тай нийцэхгүй байна.

##### Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалаар баталсан төсвийн зарлагын эдийн засгийн ангилал ашиглах зааврыг мөрдөж, батлагдсан төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байдлаар төлөвлөж зарцуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

##### 1.2 .Илрүүлэлт:

Шилэн дансанд байршуулах төсөв, өмч, хөрөнгө зарцуулах 35.5 сая төгрөгийн 4 шийдвэрийг байршуулаагүй, шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилт 75 хувьтай байна

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална.....”, 6 дугаар зүйлийн 6.4-т “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ....” , 6.4.8-д “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр” гэж заасантай нийцээгүй байна.

##### Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д заасан мэдээллүүдийг бүрэн байршуулах, цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх;

Дээрх зөвлөмжүүдийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайлан хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 05 дугаар сарын 01-ны өдрийн дотор Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Төсвийн гүйцэтгэлийн тайланд зардлыг санхүүжүүлсэн эх үүсвэрийг зөрүүтэй тайлагнасан..	1	80,692.9			1	80,692.9	1	80,692.9				
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>80,692.9</b>			<b>1</b>	<b>80,692.9</b>	<b>1</b>	<b>80,692.9</b>				

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалаар баталсан төсвийн зарлагын эдийн засгийн ангилал ашиглах зааврыг зөрчиж 210801, 210901 тоот дансаар 10.9 сая төгрөгийн зардал гаргасан.	1	10,943.5					1	10,943.5				
Нягтлан бодогч, нярав нарт 1,850.0 мянган төгрөгийн балансын шагнал олгосон	1	1,850.4			1	1,850.4						
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>12,793.9</b>			<b>1</b>	<b>1,850.4</b>	<b>1</b>	<b>10,943.5</b>				

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								

Шилэн дансанд байршуулах төсөв, өмч, хөрөнгө зарцуулах 35.5 сая төгрөгийн 4 шийдвэрийг байршуулаагүй	1	35,510.0					1	35,510.0
Дүн	1	35,510.0					1	<b>35,510.0</b>
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	1	<b>35,510.0</b>					1	35,510.0